ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль /цаашид Хууль гэх/ 1998 онд батлагдаж Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Энэ хугацаанд хуулийн 4 дүгээр зүйлд заасан үйлчлэх хүрээнд хамаарах 31661 хүний хэргийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээн 931 хүнд 43 тэрбум 780 мянган төгрөгийн нөхөн олговор олгох шийдвэр гарчээ. Энэхүү нөхөн олговорыг хэлмэгдэгчид өөрт, эсхүл түүний эхнэр буюу нөхөр, төрсөн болон үрчилж авсан хүүхэд, төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, ач, зээ нарынх нь нэхэмжлэлээр олгож ирсэн. Харин Хуульд "Нэхэмжлэл гаргах эрх нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө цагаатгагдсан иргэдийн хувьд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор, энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш цагаатгагдсан иргэдийн хувьд цагаатгасан шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 жилийн хугацаанд байна гэж зааснаас үүдэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүн 24 хүн, төрсөн болон үрчилж авсан хүүхэд 27 хүн нэхэмжлэл гаргаж нөхөн олговор авч чадалгүй хоцорчээ.

Хэдийгээр Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өнөөг хүртэл нийт 13 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байх бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтийн 5 буюу 2000, 2002, 2006, 2009, 2018 онуудад оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дурдан нэхэмжлэл гаргах хугацааг зохицуулсан 12.3 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж дээрх байдлаар нэхэмжлэл гаргах эрхээ эдэлж чадаагүй иргэдэд боломж олгож ирсэн боловч мөн л "ковидын үе таарч мэдээллээс хоцорсон, хэлмэгдэгчийн овог нэрийг тодорхойлж чадаагүй удсан, цагаатгасан талаар өөрт нь мэдэгдээгүй, хожим өөр эх сурвалжаас олж мэдсэн" гэх мэт төрлийн бүрийн шалтгаанаар 50 гаруй иргэн зөрчигдсөн эрхээ сэргээлгэж нөхөн олговор авч чадалгүй хохирсон хэвээр үлджээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн зорилго нь зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол

учруулсан иргэдийнхээ нэр төрийг нөхөн сэргээхийн сацуу, тэдэнд болон тэдний ар гэр, үр хүүхдэд зохих нөхөн олговор олгож буй ардчилсан төрийн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх явдал билээ.

Иймд нэгэнт эрх нь зөрчигдөж амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэдийнхээ хохиролыг нэгийг ч үлдээлгүй барагдуулж зохих нөхөн олговор олгох нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хууль дээдлэх ёс, шударга ёс, тэгш байдлыг хангах төрийн үйл ажиллагааны зарчимд нийцэх тул Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж нөхөн олговор авч чадаагүй үлдсэн иргэдийн нэхэмжлэл гаргах хууль зүйн боломжийг нээх практик болон хууль зүйн шаардлага үүссэн байна.

Тэгээд ч Хуулийн зорилгыг хангахын тулд хуульд өнөөг хүртэл нийт 13 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байх бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтийн 5 буюу 2000, 2002, 2006, 2009, 2018 онуудад оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дурдан нэхэмжлэл гаргах хугацааг зохицуулсан 12.3 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж байжээ. Түүнчлэн Хуулийн 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "6.3.Цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй" гэснийг Хуулийн зорилго болон түүний хэрэгжилтэд тулгамдсан практик шаардлагад нийцүүлэн 2000 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хууль, 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хууль, 2009 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хууль 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж эцэст нь 2024 оны 05 сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон байна. Гэсэн атлаа уг гомдол гаргах эрхийн үргэлжлэл болсон нэхэмжлэл гаргах эрхийг 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт уламжлалт байдлаар хугацаа тогтоон орхисон нь өдгөө 50 гаруй иргэний хилс хэрэгт шийтгүүлэн хэлмэгдсэн эрхээ сэргээлгэж нөхөн олговор авах эрхийг хязгаарласан зохицуулалт болон үлдсэн байгаа нь Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль зүйн болон практик шаардлагыг нэгэнт үүсгэжээ

Хуулийн төсөл батлагдсанаар нөхөн олговороос хоцорсон иргэдийн нэхэмжлэл гаргах эрх нээгдэж Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн Арван зургаадугаар зүйлийн 12 болон 14 дэх хэсэгт заасан эрхийг хангагдах ба шүүхээс тогтоосон хэмжээнд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид нөхөн олговор олгох тул холбогдон гарах зардлыг урьдчилан тооцож оруулсан юм.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахгүй.

---o0o---